

БАГАНУУР ХК-ИЙН НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР ХАРИЛЦАГЧДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЗОРИЛГОТОЙ ХИЙСЭН СУДАЛГАА

Энэхүү судалгааны Багануур ХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийхээр сонирхож буй харилцагчид болон Багануур ХК-ийн хувьцаа эзэмшиж буй харилцагчдадаа хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад дөхөм болгох үүднээс тодорхой мэдээллүүд дээр тулгуурлан судалгаа хийснээ та бүхэнд хүргэж байна.


Багануур ХК-ийн танилцуулга

Багануур ХК нь 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар Багануурын нүүрсний түр уурхай нэртэйгээр байгуулагдаж, жилд 200 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 1994 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэн, 75 хувийн төрийн өмчлөлтэйгээр хувьцаат компани болж, зохион байгуулалтаа өөрчилжээ. Багануур ХК-ийн эзэмшилд буй ордын нүүрсний нөөц 500 орчим сая тонн ба компанийн үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 3.8 сая тонн юм. Компанийн зүгээс мэдээллэснээр дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая тн нүүрсийг олборлон, дотоодын нийт нүүрсний хэрэгцээний 60 хувь, төвийн бүсийн 70 гаруй хувийг дангаараа хангадаг байна. Багануурын уурхай нь нийт 1,100 хүн ажиллаж байна.

Ингээд Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ болон үйлдвэрлэлийн талаарх, Багануур ХК-ийн нүүрсний үйлдвэрлэлд тулгуурлан хийгдэх гэж буй төслүүд, Багануур ХК-ийн үйлдвэрлэл, мөн санхүүгийн тодорхой мэдээлэл, хувьцааны болон нэмэлт хувьцааны нийлүүлэлтийн мэдээллийг оруулсан болно.


Цахилгааны эрчим хүчний хэрэглээ

Монгол улсад цахилгааны хэрэглээний өсөлттэй хамааралтайгаар цахилгаан үйлдвэрлэлтийн өсөлт сүүлийн жилүүдэд байдлаар 8.1 хувь хүртэл өссөн байдаг. Сүүлийн 10 жилийн хугацаанд цахилгааны үйлдвэрлэлт 93.2 хувь өссөн байдаг байна.



Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд

Цахилгааны хэрэглээний 62 орчим хувийг аж үйлдвэрлэлд ашиглагддаг ба энэ өсөлт нь 2004 оноос хойших мэдээллээс харахад энэ харьцаа төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Харин сүүлийн 3 жилийн хугацаанд нийт хэрэглэсэн цахилгааны 25-27 хувийг нь импортолсон байна.




Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд

Өрх, орон сууц, нийтийн аж ахуйн цахилгааны хэрэглээ нь нийт цахилгаан үйлдвэрлэлийн 24.2 хувийг эзэлдэг байна. Нийт цахилгааны хэрэглээнд салбаруудын цахилгааны хэрэглээний өсөлтийн хурдад өөрчлөлт байхгүй байгаа нь Монгол Улс сүүлийн 25 жилийн хугацаанд үйлдвэржилтэд төдийлөн өсөлт үзүүлээгүйтэй холбоотой. Хэрэглээ нь хүн амын өсөлт болон иргэд, ААН-ын цахилгааны хэрэглээний өсөлттэй холбож ойлгож болохоор байна.


Дулааны эрчим хүчний хэрэглээ

Дулааны үйлдвэрлэлийн хэмжээ мөн сүүлийн 10 жилийн хугацаанд 36.8 хувь өссөн байна. Харин жилийн өсөлтийн хамгийн өндөр хувь 7.2 өссөн байдаг байна.




Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд

Дулааны хэрэглээнд өрх, орон сууц, нийтийн аж ахуйн дулааны хэрэглээ нь нийт дулааны хэрэглээнд эзлэх хувь хамгийн их буюу 37.8 хувь байна.



Дулааны хэрэглээ салбар бүрт өссөн дүр зурагтай байгаа хэдий ч өрхийн хэрэглээ тасралтгүй өссөн байна.



Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд

Монгол Улсад ялангуяа хүн амын 45.7 хувь нь Улаанбаатар хотод албан ёсны бүртгэлтэйгээр амьдардаг ба тэдний 45 хувь нь орон сууцанд амьдардаг. Улаанбаатар хотод 2016 онд нийт 53 мянган айлын орон сууц ашиглалтанд орж захиалга авч эхэлсэн байгаа бол 50 мянган орчим айлын орон сууц баригдаж эхлэн, захиалгаа хараахан эхлээгүй байна. Тиймээс барилгажилт идэвхжиж иргэд орон сууцанд орсноор дулааны хэрэглээний өсөлт үргэлжлэх хүлээлттэй байна.

Багануур ХК-ний нүүрсний нийлүүлэлт

Монгол Улсад цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрсийг ашиглаж байна.

Монгол Улсын цахилгаан дулааныг нийт 5 системээр хангадаг. Хамгийн том систем нь Төвийн эрчим хүчний систем (ТЭХС) болно. Бага хэмжээтэй эрчим хүчний системүүд нь Баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС), Алтай-Улиастайн эрчим хүчний систем (АУЭХС), Даланзадгадын эрчим хүчний систем (Дал.ЭХС) болон Зүүн бүсийн эрчим хүчний систем болно. Эдгээр эрчим хүчний систем нь байгалийн саад нэн ялангуяа хүчирхэг байдлаар хоорондоо холбогдоход саад болдог уул нуруудаар тусгаарлагдсан болно.

Зураг II-2: Эрчим хүчний системүүд



ББЭХС – ягаан дөрвөлжин; АУЭХС – саарал; ТЭХС – хөх болон улаан; ЗБЭХС – ногоон; Дал.ЭХС – Өмнөговь.

Төвийн бүсийн эрчим хүчний системийг цахилгаан дулаанаар хангаж буй ДЦС2, ДЦС3, ДЦС4, Амгалангийн ЦС, ДДЦС, ЭДЦС, Багануурын ДС, Налайхын ДС-д Багануур ХК нүүрсээ нийлүүлдэг.

Багануур ХК нь эдгээр байгууллагуудад хэрэглээний нүүрсийн тодорхой хувийг нийлүүлдэг.

#	Нүүрс хэрэглэгч	ДЦС-ын нийлүүлдэг	хувийг
1	ДЦС 2	100%	
2	ДЦС 3	100%	
3	ДЦС 4	60%	
4	Амгалангийн дулааны станц	100%	
5	ДДЦС	60%	
6	ЭДЦС	50%	
7	Багануурын ДС	100%	
8	Налайх ДС	100%	

Ийнхүү Багануур ХК нь нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 70 хувь, нийт нүүрсний хэрэглээний 60 хувийг нийлүүлж байна.

/Шарын гол ХК нь ДЦС 4-ийн үлдсэн хувийг, нүүрсний хэрэглээний 30 хувийг нийлүүлдэг байна/

Багануурын уурхайд түшиглэсэн төслүүд

Түүнчлэн төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээ өсч байгаатай холбогдуулан дорх төслүүдийг хэрэгжүүлэхээр төрөөс тодорхой бодлогуудыг баримталж байна.

Багануур ХК-г түшиглэх босох өргөжилт болон шинэ хэрэглэгч

Өргөтгөл	Эрчим хүчний хэмжээ	Нүүрсний хэрэглээ
ДДЦС	50МВт	
ДЦС 3	50МВт	
ДЦС 4	100МВт	
Нийт	200МВт	0.75 сая тн
Шинэ хэрэглэгч	Эрчим хүчний хэмжээ	Нүүрсний хэрэглээ
Багануур ДЦС	700МВт	3 сая тн
ДЦС-5	450МВт	2.6 сая тн
Амгалангийн ЦС	348МВт	0.35 сая тн
Нийт	1498МВт	5.95 сая тн
Нийт нүүрсний хэрэгцээ		6.7 сая тонн нүүрс

“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого 2015-2030” хүрээнд 2 үе шаттайгаар одоо байгаа эрчим хүчний суурилагдсан чадлыг 2 дахин нэмэгдүүлэх, эрчим хүчний үүсвэрийн аюулгүй нөөцийг 20-оос доошгүй хувьд хүргэх зорилготой юм байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд ДДЦС-ыг 50 МВт-аар, ДЦС 3-ыг 50 МВт-аар, ДЦС 4-ийг 100МВт-аар өргөтгөх шийдвэрт хүрсэн. Мөн шинээр баригдах төслүүд Багануур ДЦС, ДЦС-5 байгаа ба Амгалангийн ДС нь төсөл нь хэрэгжээд үйл ажиллагаагаа эхлүүлсэн байгаа.

Багануур ХК-ийн уурхайг түшиглэн нүүрс боловсруулалтын чиглэлээр хэрэгжих төслүүд:

Үйлдвэр, төслийн нэр	Байршил	Нийт хүчин чадал /жилд/
Хэрэгжиж буй төслүүд		
“Багануур энерги” ХХК-ийн нүүрс шингэрүүлэх үйлдвэр	Багануурын уурхайн баруун хэсэг	420 мянган тонн дизель үйлдвэрлэх
Багануур” ТӨХК-ийн нүүрс шингэрүүлэх төсөл	Багануурын үйлдвэр технологийн парк	1.2 сая тонн дизель болон автобензинүйлдвэрлэх.
Хагас кокс, сайжруулсан түлшний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төслүүд		
“Хөх чоно” групп-ийн хагас коксын үйлдвэр	Багануур дүүрэг, “Багануурын ДЦС” ТӨХК	Багануурын хүрэн нүүрсээр жилд 89 000 тонн хагас кокс /шахмал түлш/ үйлдвэрлэх

Дээрх ДЦС-уудын өргөтгөл болон шинэ төслүүд хэрэгжиж эхлэх үед буюу 2020 онд Багануурын уурхайн олборлолтын хэмжээ 12-14 сая.тн-д хүрэх шаардлагатай. Энэ нь даруй одоо байгаа хүчин чадлыг даруй 3 дахин өсгөх шаардлагатай ажээ.


Одоогийн байдлаар Багануур ХК нь жилд 3.8 сая тн нүүрс олборлох хүчин чадалтай ба хүчин чадлаа бүрэн ашиглаж байна. Багануурын уурхайн нөөцийн хэмжээг 500 сая.тн байсныг өнгөрсөн жилүүдэд хайгуул хийж нөөцийг дахин тодотгосноор 1 тэрбум.тн-д хүрэх магадлалтай юм байна. Хэрэв уурхайн нөөц 1 тэрбум.тн гэсэн нөөцтэйгаар тогтоогдвол уурхайн хүчин чадлыг 14 сая.тн ба хүчин чадлыг бүрэн ашиглавал уурхайн 70 жилийн нөөцтэй гэж тодорхойлогдохоор байна.

Багануур ХК-ийн хөрөнгө, өр төлбөр болон хувьцааны ханш

Багануур ХК нийт 20,974,360 ширхэг гаргасан хувьцаатай. Хувьцааны ханш 2016.05.20 өдрийн ханш 2,750 төгрөг байна.



Компани 2015 он нийт 137.3 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй, 123.2 тэрбум төгрөгийн өр төлбөртэй. Үүнтэй холбоотойгоор дансны үнэ 672.9 төгрөг байгаа бол хувьцааны ханш 2,750 төгрөг байгаа нь хувьцааны ханш буурах хүлээлттэй харагдаж байна. Компани жил бүр эрчим хүчний хэрэглээний өсөлттэй холбоотойгоор борлуулалтын орлого өсч, 2015 онд 101.6 тэрбум төгрөгийн орлоготой байсан. Харин 2015 онд 1.93 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол өмнөх жилүүдэд 4-9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байжээ.



Компани нэмэлт хувьцаа болох нийт 9,870,287 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгоно. Тэргүүнд ээлжинд худалдан авах саналын үнэ 2,650 төгрөгөөр тооцвол 26.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг олон нийтээс татахаар харагдаж байна.

Төвийн эрчим хүчний системд голлон байр суурь эзэлдэг Багануур ХК-ийн хүчин чадлыг ойрын хугацаанд нэмэх шаардлагатай болсон дээрх судалгааг товчлон оруулбал:

- ✓ Цахилгааны хэрэглээ өсч байгаатай холбоотойгоор Монгол Улс их хэмжээний цахилгааныг импортоор авч байгаа тул Цахилгаан станцуудын төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь нүүрс нийлүүлэх Багануур ХК-ийн хүчин чадлыг зайлшгүй нэмэх шаардлагатай.
- ✓ Улаанбаатар хотын иргэдийн гэр хорооллоос орон сууцруу шилжих явц болон барилгажилт өргөжиж байгаатай холбоотойгоор дулааны хэрэглээ өснө. Тиймээс дулааны станцуудын ажлын ачаалал нэмэгдэх ба нүүрсний хэрэглээ мөн өснө.
- ✓ Багануурын уурхайн нүүрсийг ашиглан босох Багануурын ДЦС, ДЦС-5, Амгалангийн ДС-ын үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд шаардлагатай 5.95 сая.тн/жил нүүрсийг нийлүүлнэ.
- ✓ Багануурын уурхайг түшиглэн нүүрс шингэрүүлэх үйлдвэр, хагас кокс, сайжруулсан түлш үйлдвэрлэх төслүүдэд нүүрсний нэмэлт нийлүүлэлт шаардлагатай байна.
- ✓ Төвийн эрчим хүчний ситемийн бүсд шинэ аж үйлдвэржилт нэмэгдэхэд цахилгаан дулааны эрчим хүчний нөөцийг улам бүр нэмэх шаардлагатай.
- ✓ Багануурын уурхайн олборлолт одоогийн байдлаар илүү гүнрүү хийх шаардлагатай байгаа тул олборлолтын зардал мөн өссөн байна.
- ✓ Багануур ХК нь одоогийн байдлаар хүчин чадлыг хамгийн багадаа 3 дахин нэмэхээр төлөвлөж байна.

Багануур ХК нь эрчим хүчний хэрэглээтэй холбоотойгоор үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай байгаа боловч нэмэлт хувьцаа авах шийдвэрийг гаргах хөрөнгө оруулагчдийн хувьд компанийн өр төлбөр, хөрөнгө оруулалт болон компанийн удирдлага болон салбарын байдлыг үнэн бодитоор харах шаардлагатай байна.

Эрсдэл:

- ✓ Төрөөс нүүрсний компаниудын нүүрсний үнийг зах зээлийн ханшаар тогтоодоггүй. Нүүрсийг зах зээлийн ханшаар борлуулдаггүйгээс нүүрсний компаниуд алдагдалтай ажилладаг.

- ✓ Сүүлийн жилүүдэд тоног төхөөрөмжийн сайжруулалт, тогтвортой үйл ажиллагаагаар хангахтай холбоотойгоор их хэмжээний зээл авсан.
- ✓ Төр нийт хувьцааны 75 хувийг эзэмшдэг тул аливаа шийдвэрийг сангийн яамнаас гаргадаг. Энэхүү эзэмшлийн хувь 51-рүү буурсан ч гэлээ төрийн шийдвэр давамгайлсан хэвээр байна.
- ✓ Өр төлбөрийн хэмжээ их байгаатай холбоотойгоор хувьцааны дансны үнэ бага байна. Энэ нь хувьцааны ханш бууруулах бас нэг шалтгаан юм.
- ✓ Өр төлбөрийн эргэн төлөлттэй холбоотойгоор хувьцааны ханш богино биш урт хугацаанд өсөх хандлаганд орохоор байна.

Хөрөнгө оруулагчдад:

Багануур ХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулахаар шийдсэн бол доорх мэдээлэл зааврыг дагана уу!

- Уурхайн хүчин чадлыг нэмэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах зорилготойгоор нэмэлт хувьцаа гаргах асуудлыг 2016.04.11 өдрийн Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн баталсан байна.
- Мөн нэмэлт хувьцаа гаргаснаар Монгол Улсын Их хурлын 2015 оны 70-р тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн дагуу хувьчлах асуудлын хүрээнд Багануур ХК-ийн Төрийн өмчийн эзэмшилд байгаа 75 хувийг 51 хувь хүртэл бууруулах зорилготойгоор одоо байгаа 20,974,360 хувьцааг 9,870,287 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлэн нийт хувьцааны тоо 30,844,647 ширхэгт хүрэх юм.
- Энэхүү Багануур ХК-иас нэмж гаргаж буй нэмэлт хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн журмын хүрээнд хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааны **47 хувьтай** тэнцэхүйц хувьцааг **2,650 төгрөгөөр** худалдан авах эрхтэй.
- Тэргүүн ээлжинд худалдаж авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр нь 2016 оны 4-р сарын 11-ний өдөр юм.
- Энэ эрхийг хэрэгжүүлэхийн тулд 2016.04.18-2016.05.23 өдрийн хооронд Багануур ХК-д хандана. Ингэхдээ тэргүүн ээлжинд худалдан авах хүсэлтийг бөглөн, шаардлагатай төлбөрийг зааврын дагуу хийн, төлбөрийн баримттай хамт Багануур ХК-ийн байранд хүргүүлнэ, эсвэл үйлчлүүлдэг ҮЦК-д өгөх юм.
- Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээсээ татгалзсан хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээ нь нэмэлт хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор нэмж гаргаж буй хувьцаатай хувь тэнцүүлэн багасахыг анхаарна уу.

Тэргүүн ээлжийн хувьцааны төлбөр хүлээн авах мэдээлэл:

- Хэнээс Нэр
- Орлого хүлээн авагчийн нэр “Багануур” ХК
- Хүлээн авагчийн банк Худалдаа хөгжлийн банк
- Дансны дугаар 499241441
- Төлбөрийн зориулалт Хувьцааны үнэ + шимтгэл

- Дэлгэрэнгүй мэдээллийг “Багануур” ХК-ийн өөрийн байр, 2 давхар 201 тоот өрөө хаягаас болон Хэвлэл мэдээллийн ажилтан: С.Одончимэг, Утас: 99044373, sanjaa_oogii@yahoo.com